

## “ИНЖЕНЕР, ТЕХНОЛОГИЙН ДЭЭД БОЛОВСРОЛ” ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

### Төслийн зорилго:

Монгол Улсад өндөр мэдлэг, ур чадвар бүхий инженер, техник технологийн мэргэжилтэн бэлтгэх, тэднийг чадавхижуулах, инженер техникийн боловсролын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, багшлах хүний нөөцийг бэхжүүлэх, сургалтын орчныг шинэчлэх, чанарыг сайжруулахад оршино.

### Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:

Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яам  
Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/

### Төслийн санхүүжилт:

Япон Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээл

Төсөл хэрэгжүүлэх хугацаа: 2014 оны 06 сараас 2023 оны 3 сарын хооронд



### Төслийн үр дүн, ач холбогдол:

- МУИС, ШУТИС-ийн инженер бэлтгэх хөтөлбөр олон улсын жишигт хүрнэ.
- Аж үйлдвэрийн салбарын эрэлтэд нийцсэн практик чадвар бүхий 1000 гаруй инженер, техникийн ажилтан бэлтгэгдэнэ.
- Тэргүүлэх 20 чиглэлээр олон улсын хамтарсан судалгаа хийгдэж, бодит үр дүнг практикт шилжүүлж нэвтрүүлнэ.
- Дэлхийн шилдэг их, дээд сургуулиудын хөтөлбөрт дүйцсэн инженерийн боловсролыг 8.4 дахин хямд өртгөөр эзэмшинэ.

### Төсөлд хамрагдах хөтөлбөрүүд:

Хөтөлбөрүүд	Япон улсад суралцах хугацаа	Суралцах хүний тоо
Коосэн сургалтын хөтөлбөр	3 жил	200
Хамтарсан бакалаврын сургалтын хөтөлбөр	2 жил	320
Магистрын сургалтын хөтөлбөр	2 жил	60
Докторын сургалтын хөтөлбөр	3 жил	100
Зэргийн бус сургалтын хөтөлбөр	1 жил хүртэлх	320

### НЭГ. “КООСЭН” СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Япон улсын эдийн засгийн өсөлт 1950-аад оны сүүлчээр шинжлэх ухаан, технологид суурилан үсрэнгүй нэмэгдсэн нь олон тооны инженер бэлтгэх хэрэгцээ үүсгэжээ. Үүний дүнд 1962 оноос анх Японы үндэсний технологийн коллеж “Коосэн” байгуулагдсан юм. “Коосэн” нь инженер, техник технологийн өндөр мэдлэг, ур чадвар бүхий мэргэжилтэн бэлтгэхдээ дадлага, туршилтыг түлхүү анхаарахын зэрэгцээ их сургуулийн түвшний онолын болон практик мэдлэг олгодог ороо оңцлогтой. Тус сургуулийг төгсөгчид нь үйлдвэрлэл технологийг мэргэжлийн түвшинд удирдаж Японы хөгжил дэвшлийн манлайлагчид болжээ.

Монголын залуучуудыг энэ хөтөлбөрийн хүрээнд 2014 оноос эхлэн “Коосэн” сургалтын хөтөлбөрт дараах хоёр шаттайгаар сонгон шалгаруулж, суралцуулна.

#### А. “Коосэн” сургуульд шууд элсэн суралцах хөтөлбөр:

Суралцагчдад тавигдах шаардлагыг бүрэн хангаж, шалгалтанд /Япон хэл/ тэнцсэн оюутан 2015 оны 03 дугаар сараас эхлэн Япон Улсын “Коосэн” хөтөлбөрт шууд элсэн суралцана. 3 жил суралцаж, бакалаврын өмнөх зэргийн дипломтой төгсөнө. Мөн сургуулиа төгсөөд ажиллаж байх хугацаандаа МУИС, ШУТИС-тай байгуулсан гэрээний дагуу “Коосэн” сургалтын хөтөлбөрийн кредитийг дүйцүүлэн нэмэлт сургалтанд хамрагдаж, бакалаврын боловсрол эзэмших боломжтой.

Бүртгэлийн хугацаа: 2014.08.25 – 2014.09.05-ны хооронд

Сургалт эхлэх хугацаа: 2015.03 дугаар сар

#### Б. “Коосэн” сургуулийн бэлтгэл сургалтанд элсэн суралцах хөтөлбөр:

Суралцагчдад тавигдах шаардлагыг бүрэн хангаж, шалгалтанд тэнцсэн оюутан ШУТИС дээр хичээллэх бэлтгэл сургалтын хөтөлбөрт 1,5 жил суралцаж, Япон Улсад суралцах элсэлтийн шалгалт өгч, тэнцсэн тохиолдолд Япон Улсын “Коосэн” сургуульд инженер, технологийн чиглэлээр 3 жил шилжин суралцаж, бакалаврын өмнөх зэргийн дипломтой төгсөнө. Хэрэв шалгалтанд тэнцээгүй тохиолдолд гэрээний дагуу кредит дүйцүүлэн МУИС болон ШУТИС-д үргэлжлүүлэн суралцах болно. Монгол Улсад суралцах 1.5 жилийн сургалтын төлбөрийг оюутан өөрөө хариуцна. Тус сургалтын 1 кредитийн үнэлгээ нь ШУТИС-ийн кредитийн үнэлгээтэй ижил байна.

Мөн сургуулиа төгсөөд ажиллаж байх хугацаандаа МУИС, ШУТИС-тай байгуулсан гэрээний дагуу “Коосэн” сургалтын хөтөлбөрийн кредитийг дүйцүүлэн нэмэлт сургалтанд хамрагдаж, бакалаврын боловсрол эзэмших боломжтой.

Бүртгэлийн хугацаа: 2014.08.25 – 2014.09.05-ны хооронд

Сургалт эхлэх хугацаа: 2014.09 дүгээр сар

### “Коосэн” сургалтын хамрах хүрээ:

- а/ Монгол Улсын их, дээд сургууль, коллежид инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр суралцаж байгаа оюутан  
б/ Инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр аж үйлдвэр, эрдэм шинжилгээний салбарт ажиллаж байгаа ажилтан  
в/ 2014 онд бүрэн дунд сургуулийг төгсөгчид

### ТАВИГДАХ ШААРДЛАГА

- а/ Монгол улсын иргэн байх;  
б/ Бүрэн дунд сургууль төгссөн байх;  
в/ Элсэлтийн ерөнхий шалгалт /математик, физик эсвэл математик, хими-ын оноо 500 ба түүнээс дээш байх эсвэл инженер, технологийн чиглэлээр суралцаж байгаа бол суралцсан хугацааны сурлагын голч дүн 2.5 ба түүнээс дээш байх;  
г/ Гадаад хэлний шалгалт: Япон хэлний JLPT шалгалт-N2 төвшин ба түүнээс дээш байх; /Бэлтгэл сургалттай “Коосэн” сургалтын хөтөлбөрт хамаарахгүй/  
д/ Сургууль /ажлын газар/ нь тус сургалтын хөтөлбөрт суралцахыг дэмжсэн байх;  
е/ Техник, технологийн чиглэлээр суралцах сонирхолтой, “Коосэн” сургуулиа төгсөөд аж үйлдвэрийн салбаруудад шууд ажиллах хүсэлтэй байх;  
ё/ 25 наснаас доош;

### БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

- а/ Анкет /маягтын дагуу/  
б/ Иргэний үнэмлэх нотариатаар баталгаажуулсан хуулбар  
в/ Бүрэн дунд боловсролын гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар (хэрэв түүнээс дээш шатны боловсрол эзэмшсэн бол гэрчлэх баримт бичгийн хуулбар)  
г/ Элсэлтийн ерөнхий шалгалтын батламжийн нотариатаар баталгаажуулсан хуулбар  
д/ Элсэн суралцах эрхийн бичиг /Шууд элсэх “Коосэн” сургалтын хөтөлбөрт хамаарахгүй/  
е/ Япон /Англи/ хэлний шалгалт өгсөн батламжийн нотариатаар баталгаажуулсан хуулбар, сүүлийн 2 жил дотор өгсөн байх /Бэлтгэл сургалттай “Коосэн” сургалтын хөтөлбөрт хамаарахгүй/  
ё/ Сургуулийн /ажлын газрын/ тодорхойлолт  
ж/ Тухайн мэргэжлийг сонгосон шалтгаан, төгссөний дараа ажиллах тухайгаа монгол-англи эсвэл монгол-япон хэл дээр бичсэн 500-800 үгтэй эссе  
з/ Эрүүл мэндийн тодорхойлолт (сонгон шалгаруулалтад тэнцсэн хүмүүс бүрдүүлэх) /Бэлтгэл сургалттай “Коосэн” сургалтын хөтөлбөрт хамаарахгүй/  
и/ 3x4 хэмжээтэй 2 хувь цээж зураг (сүүлийн 3 сард авахуулсан байх)  
й/ Бүртгэлийн хураамж төлсөн баримт

### ХОЁР. МОНГОЛ-ЯПОНЫ ХАМТАРСАН БАКАЛАВРЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Суралцагчдад тавигдах шаардлагыг бүрэн хангаж, шалгалтанд тэнцсэн оюутан ШУТИС дээр хичээллэх хамтарсан бакалаврын сургалтын хөтөлбөрт элсэн суралцана. Хамтарсан сургалтын хөтөлбөрт 2.5 жил амжилттай суралцсан оюутан Япон Улсын их, дээд сургуульд “Шилжин суралцах шалгалт” өгнө. Тэнцсэн оюутан Япон Улсад үргэлжлүүлэн 2 жил суралцаж, хоёр улсын их, дээд сургуулийн бакалаврын зэрэгтэй төгсөнө. Монгол Улсад суралцах 2.5 жилийн сургалтын төлбөрийг оюутан өөрөө хариуцна. Тус сургалтын 1 кредитийн үнэлгээ нь ШУТИС-ийн кредитийн үнэлгээтэй ижил байна.

### Хамрах хүрээ:

- а/ Барилга архитектур, Механик инженерийн чиглэлээр ШУТИС-д 2015-2016 оны хичээлийн жилд элссэн оюутан

Бүртгэлийн хугацаа: 2015.08 дугаар сар

## ТАВИГДАХ ШААРДЛАГА



- а/ Монгол улсын иргэн байх;
- б/ Бүрэн дунд сургууль төгссөн байх;
- в/ Элсэлтийн ерөнхий шалгалт /математик, физик эсвэл математик, хими-ын оноо 500 ба түүнээс дээш байх;
- г/ Сургууль нь тус сургалтын хөтөлбөрт суралцахыг дэмжсэн байх;
- д/ Сургуулиа төгсөөд шууд ажиллах хүсэлтэй байх;
- е/ Суралцсан хугацааны сурлагын голч дүн 2.5 ба түүнээс дээш байх;
- ё/ 25 наснаас доош;

## БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ



- а/ Анкет /маягтын дагуу/
- б/ Иргэний үнэмлэх нотариатаар баталгаажуулсан хуулбар
- в/ Бүрэн дунд боловсролын гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар (хэрэв түүнээс дээш шатны боловсрол эзэмисэн бол гэрчлэх баримт бичгийн хуулбар)
- г/ Элсэлтийн ерөнхий шалгалтын батламжийн нотариатаар баталгаажуулсан хуулбар
- д/ Сургуулийн тодорхойлолт
- е/ 3x4 хэмжээтэй 2 хувь цээж зураг /сүүлийн 3 сард авахуулсан байх/
- ё/ Бүртгэлийн хураамж төлсөн баримт

## ГУРАВ, МАГИСТР, ДОКТОРЫН СУРГАЛТ БОЛОН ЗЭРГИЙН БУС СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Монгол Улсад нэн шаардлагатай тэргүүлэх чиглэлийн судалгааны сэдвээр эрдэм шинжилгээ, судалгааны ажилд хамтран ажиллаж байгаа багш, судлаачид тус сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагыг бүрэн хангаж, шалгалтанд тэнцсэн иргэд Япон Улсын их, сургуульд магистрт 2, докторт 3, зэргийн бус сургалтын хөтөлбөрт 1 жил хүртэлх хугацаагаар сургалт, судалгаанд хамрагдана.

## Хамрах хүрээ:

а/ Инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр гадаад дотоодын их, дээд сургуулийг бакалавр болон докторын хөтөлбөрт суралцаж байгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн, үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байгаа

б/ Инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр Монгол Улсын их, дээд сургуулийн магистр болон докторын хөтөлбөрт суралцаж байгаа

в/ МУИС болон ШУТИС-д инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр магистраас дээш зэрэгтэй ажиллаж, суралцаж байгаа багш, ажилтан мөн Монгол Улсад нэн шаардлагатай тэргүүлэх чиглэлийн судалгааны сэдвээр эрдэм шинжилгээ, судалгааны ажилд хамтран ажиллаж байгаа судлаачид зэргийн бус хөтөлбөрт хамрагдана.

Бүртгэлийн хугацаа: 2014.08.25-09.05-ны хооронд

## ТАВИГДАХ ШААРДЛАГА



- а/ Монгол улсын иргэн байх;
- б/ Монгол улсын магадлан итгэмжлэгдсэн болон гадаадын их, дээд сургуулийг инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр бакалавр /магистр, доктор/-ын хөтөлбөрийг дүүргэсэн байх;
- в/ Дипломын голч дүн: бакалавр 2.5-аас, магистр 2.7-аас дээш байх;
- г/ Гадаад хэлний шалгалт: Япон хэлний JLPT шалгалт-N2 төвшин эсвэл Англи хэлний TOEFL шалгалт PBT-350, CBT-210, IBT-70, IELTS шалгалт-5.0, TOEIC шалгалт-600/ ба түүнээс дээш байх; /Гадаадын хэлний шалгалтын оноо зэргийн бус суралтанд хамрахааргүй/
- д/ Японы их, дээд сургуулиудад элсэн суралцах болзол хангаж, суралцах урилга хүлээн авсан байх; /Зэргийн бус суралтанд хамрахааргүй/
- е/ Мэргэжлээрээ ажилласан жил: магистрын хөтөлбөрт 2, докторын хөтөлбөрт 3-аас доошгүй жил ажилласан байх;
- ё/ Сургууль /ажлын газар/ нь тус сургалтын хөтөлбөрт суралцахыг дэмжсэн байх
- ж/ Төслийн хүрээнд хэрэгжиж буй тэргүүлэх чиглэлийн хамтарсан судалгаанд оролцдог байх;
- з/ Судалгааны ажлын төлөвлөгөө, эрдэм шинжилгээний бүтээлтэй байх;
- и/ Магистр 30 наснаас доош, доктор 35 наснаас доош байх;

## БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ



- а/ Анкет /маягтын дагуу/
- б/ Иргэний үнэмлэх нотариатаар баталгаажуулсан хуулбар
- в/ Бакалавр /магистр, доктор/-ын дипломын нотариатаар баталгаажуулсан хуулбар
- г/ Япон /Англи/ хэлний шалгалт өгсөн батламжийн нотариатаар баталгаажуулсан хуулбар /сүүлийн 2 жил доктор өгсөн байх/
- д/ Япон талаас суралцах эрхийн бичиг /Зэргийн бус сургалтын хөтөлбөрт хамрахааргүй/
- е/ Сургуулийн /ажлын газрын/ тодорхойлолт
- ё/ Эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт
- ж/ 2 талын профессорын тодорхойлолт
- з/ Сургуулиа төгссөний дараа мэргэжлээрээ хэрхэн ажиллах тухайгаа монгол-англи эсвэл монгол-япон хэл дээр бичсэн 500-800 үгтэй эссе
- и/ 3x4 хэмжээтэй 2 хувь цээж зураг /сүүлийн 3 сард авахуулсан байх/
- й/ Бүртгэлийн хураамж төлсөн баримт
- к/ Батлан даалтын гэрээ /Магистр, докторын сургалтын хөтөлбөрт хамрахааргүй/

✓ Япон Улсад инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр нийт 1000 гаруй оюутан дээрх сургалтын хөтөлбөрт хамрагдана. Суралцах хугацаанд нь сургалтын төлбөр, амьжиргааны зардал, замын зардлыг зээлээр олгоно. Суралцагч сургалтын хөтөлбөрүүдэд амжилттай суралцаж, төгсөж ирээд Монгол улсад 5 жил тогтвортой ажилласан тохиолдолд энэхүү сургалтын зээл нь тэтгэлэг болно.

## Бүртгэл баталгаажуулалт:

Сургалтын хөтөлбөрүүдэд элсэн суралцах суралцагчдын бүртгэлийг онлайн хэлбэрээр төслийн цахим хуудсаар урьдчилсан бүртгэлийг хийнэ.

Цахим хуудас: [www.mjeed.edu.mn](http://www.mjeed.edu.mn) утас: 315563

2014.09.03-09.05-ны өдрүүдэд ШУТИС-ийн Төв номын сангийн 605 тоотод бичиг баримтыг бүрдүүлэн ирж, бүртгэлээ баталгаажуулна. Бүртгэлийн хураамж 10.000 төг.



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



ШИНЖЛЭХ УХААН,  
ТЕХНОЛОГИЙН  
ИХ СУРГУУЛЬ



МОНГОЛ УЛСЫН ИХ  
СУРГУУЛЬ

1000  
ИНЖЕНЕР

ИНЖЕНЕР,  
ТЕХНОЛОГИЙН  
ДЭЭД БОЛОВСРОЛ

"Инженер, технологийн дээд боловсрол" төсөл  
Хаяг: ШУТИС-ийн Төв номын сангийн 605 тоот  
Цахим шуудан: [www.piu1000@mecs.gov.mn](mailto:www.piu1000@mecs.gov.mn)  
Цахим хуудас: [www.mjeed.edu.mn](http://www.mjeed.edu.mn)  
Утас: +(976)11-315563  
Факс: +(976)11-315563